



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/205

Мандалговь

Г Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх т
ашиглалтад оруулах арга хэмжээний тухай

Монгол улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 170 дугаар тогтоолын 3.13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖИЛАХ нь:

Нэг. Барилга, Хот байгуулалтын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 194 дүгээр тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар тогтоох дүрэм"-ийн хавсралт бага, дунд, өндөр төвөгшилийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг хөрөнгийн эх үүсвэр харгалзахгүйгээр барилга угсралтын ажилд захиалагчийн хяналтын гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж /-т үүрэг болгосугай.

Хоёр. Магадлал хийсэн зураг төсөвгүй, захиалагчийн хяналт гүйцэтгэх болон зохиогчийн хяналт хийх гэрээ байгуулаагүй, барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөлгүй барилга байгууламжийг ашиглалтад оруулахгүй байхыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Гурав. Энэхүү захирамжид хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Ш.Төрбат/-т даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

О.БАТ-ЭРДЭНЭ

0270584

